

НЭГ. ЭРҮҮДЭН ШҮҮХТЭЙ ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан, МХХ-ны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Ц.Жаргалан

1.1. Олон улсын хэм хэмжээ

Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх (эрүүдэн шүүх, бусад хүнлэг бус харьцаа) үйлдэл тус бүр ялгаатай бөгөөд эдгээрийг тус тусад нь авч үзэж, эрүүгийн хууль тогтоомжид тусгах нь зүйтэй. Олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд гагц “эрүүдэн шүүх” үйлдлийг тодорхойлсон бөгөөд бусад хэлбэрийг тодорхойлоогүй юм. “Эрүүдэн шүүх” тодорхойлолтыг анх удаа НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (ЭШЭК гэх)-ийн 1-р зүйлд “Энэхүү конвенцын зорилгын дагуу “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гурав дах этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах тухайн хүн буюу гурав дах этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дах этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ.”¹ гэжээ. Мөн Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 7 дугаар зүйлийн 2 дох хэсгийн (e) заахдаа “эрүү шүүлт тулгах” гэж цагдан хоригдож байгаа этгээд буюу хараа хяналтад яллагдагчид хүчтэй өвдөлт буюу бие махбодын болон сэтгэл санааны зовуурь шаналгаа

учруулсныг хэлнэ.” хэмээн тодорхойлсон байна.

ЭШЭК-ийн 4-р зүйлийн дагуу оролцогч улс нь “эрүүдэн шүүх” үйлдлийг бусад гэмт үйлдлээс салгаж, тусад нь гэмт хэрэгт тооцох үүрэг хүлээдэг.²

Харин “бусад хүнлэг бус харьцаа” гэж юу болох талаар олон улсын хүний эрхийн эрх зүйд тодорхойлолт байхгүй байна. Гэвч НҮБ-ын хүний эрхийн механизмууд нь улс орны ЗГ-ын тайланг хэлэлцэх, хувь хүмүүсийн болон улс хоорондын гомдлыг шийдвэрлэх, хяналт шалгалт хийх явцдаа зарим жишиг тогтоогоод байна. Мөн зарим улс орнууд эрүүгийн хууль тогтоомждоо “бусад хүнлэг бус харьцаа”-г тусгайлан гэмт хэрэгт тооцсон жишиг байна.

1.2. НҮБ-ын зөвлөмж

Монгол Улсын хүний эрхийн нөхцөл байдалд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн I, II циклээс дүгнэлт хийж, нийт 6 улс “эрүүдэн шүүх” гэмт хэргийг ЭШЭК-ийн 1-р зүйлд нийцүүлэн томъёолохыг Монгол Улсад зөвлөсөн билээ.³

НҮБ-ын Хүний эрхийн хороо Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 6 дах удаагийн тайланг хэлэлцээд өгсөн дүгнэлт зөвлөмждөө “шинэ Эрүүгийн хуулийн

¹ НҮБ-ын НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 39/46, Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх тухай конвенц, 1984 он, Монгол Улс 2002 онд соёрхон баталсан. Зүйл 1

² “Guide on anti-torture legislation”, Association for the Prevention of Torture (APT) and Convention against Torture Initiative (CTI), 2016, https://www.apr.ch/content/files_res/anti-torture-guide-en.pdf

³ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I, II цикл, 2010 он, 2015 он, Англи Улс, 84.19, Мексик 84.20, Гана Улс 84.21, Нидерланд Улс 84.22, Унгар Улс 108.74, Коста Рика 108.80

21 дүгээр зүйлийн 21.12 заалтад туссан “эрүүдэн шүүх” гэмт хэрэг нь хувь хүмүүсийн үйлдсэн эрүүдэн шүүх үйлдлийг хамааруулаагүй тул Пактад бүрэн нийцэхгүй байна” хэмээн шүүмжилсэн байна.⁴ Мөн Хороо “эрүүдэн шүүх” гэмт хэрэгт оногдуулах хорих ял 5 жил хүртэл байгаа нь тухайн гэмт хэргийн онц аюултай шинжид тохирохгүй бага шийтгэл хэмээн дүгнээд “эрүүдэн шүүх” гэмт хэргийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн томъёолох, онц аюултай шинжид нь тохирох ял шийтгэл оногдуулахыг зөвлөсөн.⁵

Эрүүдэн шүүхийн эсрэг хороо (ЭШЭХ гэх) ЭШЭЖ-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ЗГ-ын 2 дугаар илтгэлийг хэлэлцээд “айлган сүрдүүлэх, дарамт шахалт үзүүлэх, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах” зорилгыг тусгаагүй, мөн “гуравдагч этгээдийн эсрэг үйлдэх явдлыг” тодорхойлолтод тусгаагүй, мөн торгох, эсхүл 5 жил хүртэл хорих ялтай байгаа нь эрүүдэн шүүх гэмт хэргийн онц аюултай шинжид тохирохгүй байна” гэж дүгнэсэн.⁶ ЭШЭХ нь “эрүүдэн шүүх сэдэл болон шалтаг болсон бүх төрлийн ялгаварлан гадуурхалт, айлган сүрдүүлэлт болон дарамт шахалт үзүүлэх хэлбэрүүд, гуравдагч этгээдийн эсрэг эрүүдэн шүүлтийг оролцуулан ЭШЭЖ-ийн 1-р зүйлд байгаа бүх бүрэлдэхүүн хэсгийг тусгасан “эрүүдэн шүүх” гэмт хэргийг тодорхойлох”-ыг зөвлөсөн.⁷ Мөн ЭШЭЖ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2 дах заалтын дагуу “эрүүдэн шүүх гэмт хэргийн ял шийтгэлээс мултрахтай тэмцэх, энэ хэргийн онц аюултай шинжид тохирох ял шийтгэл оногдуулах”-ыг зөвлөсөн билээ.⁸

Үүний зэрэгцээ “эрүүдэн шүүх” гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй байхыг зөвлөсөн.⁹

1.3. Нөхцөл байдлын үнэлгээ

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд... эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө...” хэмээсэн нь зөвхөн эрүүдэн шүүлт тулгахыг үл хөндөнө гэсэн олон улсын хэм хэмжээнээс илүү өргөнөөр авч үзжээ. Эрүүдэн шүүх гэмт хэрэг Эрүүгийн хуульд хэрхэн туссаныг авч үзвэл тус хуулийн 21.12 дугаар зүйлд “эрүүдэн шүүх” гэмт хэргийг тусгаж, 10.1 дүгээр зүйлийн 2.12-т “эрүүдэн шүүж” хүнийг алсан бол, 11.1 дүгээр зүйлийн 2.1-т “эрүүдэн шүүж” хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан бол, 11.4 дүгээр зүйлийн 2.1-т “эрүүдэн шүүж” хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол, 11.6 дугаар зүйлийн 2-т “эрүүдэн шүүж” хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан бол гэсэн тухайн зүйлийн гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөлд оруулан 5 тусдаа хэсэгт тусгажээ. Ял шийтгэлийн тухайд тус бүрдээ ялгавартай байна. Тухайлбал, “эрүүдэн шүүх” гэмт хэрэг буюу 21.12-т 2,700-5,400 нэгжийн торгууль, эсхүл 5 хүртэл жилийн хорих ял оногдуулахаар байна. Дээрх заалтуудаас хамгийн хүнд шийтгэл нь эрүүдэн шүүж хүнийг алсан бол 12-20 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл бүх насаар хорих ял юм. Ийнхүү “эрүүдэн шүүх” гэмт хэрэгт оногдуулах ялыг тухай бүрд ялгавартай авч үзсэн нь ЭШЭЖ-ийн 4-р зүйлээр “эрүүдэн шүүхийг бусад гэмт үйлдлээс салгаж, тусад нь гэмт хэрэгт тооцох” үүрэгтэй зөрчилдөж байна.¹⁰ Мөн Эрүүгийн хуулийн “эрүүдэн шүүх” гэсэн тодорхойлолт ЭШЭЖ-ийн 1-р зүйлд бүрэн нийцэхгүй байгаа тухай Хүний эрхийн хороо, ЭШЭХ-оос өгсөн дүгнэлт зөвлөмжийг анхаарч үзэх шаардлагатай. ЭШЭЖ-ийн “эрүүдэн шүүх” тодорхойлолтыг Эрүүгийн хуулийн тодорхойлолттой харьцуулсныг хүснэгтээр харуулав. ЭШЭЖ-оор “эрүүдэн шүүх” үйлдлийг хэзээ ч зөвшөөрч үл болох “онц аюултай” гэмт хэрэгт тооцдог. Тиймээс ч Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т онц болон дайны байдал зарласан нөхцөлд ч хязгаарлаж үл болох

⁴ UN Human Rights Committee, Concluding Observations on the sixth periodic report of Mongolia, 2017, CCPR/C/MNG/CO/6, para. 21

⁵ UN Human Rights Committee, Concluding Observations on the sixth periodic report of Mongolia, 2017, CCPR/C/MNG/CO/6, para. 22

⁶ UN CAT, Concluding Observations on the second periodic report of Mongolia, 2016, CAT/C/MNG/CO/2, para.9

⁷ UN CAT, Concluding Observations on the second periodic report of Mongolia, 2016, CAT/C/MNG/CO/2, para.10 (a)

⁸ UN CAT, Concluding Observations on the second periodic report of Mongolia, 2016, CAT/C/MNG/CO/2, para.10 (b)

⁹ UN CAT, Concluding Observations on the second periodic report of Mongolia, 2016, CAT/C/MNG/CO/2, para.10 (c)

¹⁰ UN CAT, General Comment No2 (Article 2), (2008.01.24), CAT/C/GC/2, Para. 11

бие махбодын, сэтгэл санааны **хүчтэй өвтгөн, шаналгах** үйлдэл

бусдын бие махбод, сэтгэл санааг **шаналган зовоосон**

Санаатай үйлдэл

Санаатай

өөрөөс нь эсхүл гуравдагч этгээдээс мэдээ, мэдүүлэг авах, үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт өөрийг нь эсхүл гуравдагч этгээдийг шийтгэх, өөрийг нь эсхүл гуравдагч этгээдийг айлган сүрдүүлэх эсхүл шахалт үзүүлэх эсхүл аливаа хэлбэрээр ялгаварлах зорилго бүхий

тайлбар, мэдүүлэг авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, ялгаварлах зорилгоор

Төрийн албан хаагч, эрх бүхий бусад этгээд эсхүл тэдний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр

Төрийн албан хаагч өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаагаа илэрхийлж

эрхэд “эрүүдэн шүүхээс ангид байх эрх” багтдаг. Мөн ИУТЭОУП-ын 4 дүгээр зүйлийн 4.2-т ухрах үндэслэл болохгүй, туйлын эрх болохыг баталгаажуулсан. Тийм ч учраас ЭШЭХ нь 2002 онд эрүүдэн шүүх гэмт хэргийн онц аюултай шинжийг харгалзан үзэж 6-20 жилийн хорих ял оногдуулах нь зүйтэй болохыг оролцогч улсуудад зөвлөжээ.¹¹

ЭШЭХ-оос эрүүдэн шүүх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй байхыг зөвлөсөн ч Эрүүгийн хуулиар “эрүүдэн шүүх” гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа 5 жил, эрүүдэн шүүж амь насыг нь хөнөөсөн бол 20 жил, эрүүл мэндэд нь хүнд гэмтэл учруулсан бол 12 жил байхаар тогтоожээ.

Эрүүгийн болон Зөрчлийн хуулиар “бусад хүнлэг бус харьцаа”-г гэмт хэрэгт тооцоогүй. Үндсэн хуульд онц болон дайны байдал зарласан тохиолдолд ч хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө гэсэн нь цаашид Үндсэн хуульд нийцүүлэн Эрүүгийн хуулиар хүнлэг бус, хэрцгий хандах үйлдлийг гэмт хэрэгт тооцох шаардлага буй болохыг харуулж байна. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оролцогчдын “хүнлэг бус харьцаанаас ангид байх эрх”-ийг тусгаж, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, гэрчээс мэдүүлэг авахдаа хүнлэг бусаар харьцахыг хориглосон байна.¹² Харин ийнхүү хориглосон үйлдлийг хийсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг орхигдуулжээ.

1.4. Зөвлөмж

Эрүүгийн хуульд дараах зүйлийг тусгах нь зүйтэй. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 10.1, 11.1.2.1, 11.4.21, 11.6.2, 21.12 дугаар зүйлд тусгасан “Эрүүдэн шүүх” үйлдэлд хамаарах гэмт хэрэг тус бүрийг нэгтгэн, нэг гэмт хэрэг болгон зүйлчлэх, ингэхдээ ЭШЭК-ийн 1-р зүйлд заасан тодорхойлолтод бүрэн нийцүүлэх, үүний тулд Хүний эрхийн хороо, ЭШЭХ-ны зөвлөмжид тулгуурлах;
- Эрүүдэн шүүх гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг онц аюултай шинжид нь нийцүүлэх;
- Эрүүгийн хуульд “бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх” үйлдлийг гэмт хэрэгт тооцож, шинээр зүйлчлэх;
- “Эрүүдэн шүүх” гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй байх тухай НҮБ-ын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмжийг харгалзан үзэх;
- Хувь этгээд буюу төрийн бус оролцогчийн үйлдэж буй эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцох асуудлыг Хүний эрхийн хороо, ЭШЭХ-ны зөвлөмжид тулгуурлан судалж, шийдэх.

¹¹ Association for the Prevention of Torture and Convention against Torture Initiative, Guide on anti-torture legislation, 2016, p.21

¹² УИХ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он, www.legalinfo.mn, 1.9 дүгээр зүйл

ХОЁР. ЭРҮҮДЭН ШҮҮЛГЭСЭН ХҮН ХОХИРЛОО БАРАГДУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ

ХЭҮК-ын Гомдол хариуцсан референт Б.Мөнхэрдэнэ, Өмгөөллийн Ананд адвокатс ХХН-ийн Ахлах өмгөөлөгч Ү.Амарбат, ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан

2.1. Олон улсын хэм хэмжээ

ИУТЭОУП-ын 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй”, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Оролцогч улс өөрийн эрх зүйн тогтолцоогоороо эрүүдэн шүүгдсэн этгээд хохирлоо арилгуулах, шударга, хангалттай нөхөн төлбөр авах эрх, түүний дотор эрүүл мэндээ бүрэн сэргээхэд шаардлагатай төлбөр гаргуулах эрхийг хүлээн зөвшөөрнө. Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогч нас барвал асран халамжлагч нөхөн төлбөр авах эрхтэй.” гэж заасан ба тус заалтын 2 дахь хэсэгт “Энэхүү зүйл нь хохирогч буюу бусад этгээд дотоодын хууль тогтоомжийн дагуу нөхөн төлбөр авах эрхийг хөндөхгүй” гэжээ. ЭШЭХ-ны 3-р ерөнхий зөвлөмжид 14-р зүйл нь “...эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус харьцааны улмаас хохирсон бүх хохирогчид хамаатай” гэж үзсэн.¹³

ЭШЭХ нь хохирлыг бүрэн дүүрэн барагдуулах гэдэг нь эрхийг сэргээх, нөхөн олговор олгох, нөхөн сэргээх, төр хариуцлага хүлээх, тухайн үйлдэл дахин давтагдахгүй байх асуудлыг агуулна хэмээн тайлбарласан.¹⁴ Мөн хохирогч нь ЭШЭК-ийн дагуу эрүүдэн шүүсэн этгээдийг тогтоосон эсэх, мөрдөн шалгагдаж, шүүгдэж байгаа эсэхээс үл хамааран хохирлоо барагдуулахаар нэхэмжлэх эрхтэй.¹⁵ ЭШЭК-ийн 14-р зүйлээр оролцогч улсууд нь хохирогчийн хохирлыг барагдуулах хүрээнд гомдлын механизм бий болгох, мөрдөн шалгах институц, хараат бус шүүхтэй байхын зэрэгцээ эдгээр механизм үр дүнтэй ажиллаж, бүх

хохирогчдод хүртээмжтэй байх, нөхөн олговор, бүрэн нөхөн сэргээх асуудлыг багтаасан үр дүнтэй хохирол барагдуулах баталгааг бүрдүүлсэн байхыг ойлгоно.¹⁶

Мөн түүнчлэн Олон улсын хүний эрхийн хуулийн бүх зөрчил, Олон улсын хүмүүнлэгийн хуулийн ноцтой зөрчлийн хохирогчдыг нөхөн сэргээх, хохирол барагдуулах талаарх НҮБ-ын наад захын зарчим, удирдамжид хохирол барагдуулах асуудлаар чухал зөвлөмж, чиглэмжийг өгсөн байдаг.¹⁷

2.2. НҮБ-ын зөвлөмж

НҮБ-ын Эрүүдэн шүүхтэй тэмцэх тусгай илтгэгч Манфред Новак Монгол Улсын Засгийн газарт “...эрүү шүүлт, бусад хүнлэг бус харьцаанд өртөж хохирсон хохирогчид хангалттай нөхөн олговор болон хүртээмжтэй эмчилгээ, нөхөн сэргээлт авах нөхцөл бүрдүүлэх” зөвлөмжийг ирүүлсэн байна.¹⁸

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс “...эрүүдэн шүүгдсэний улмаас хохирогчдод олгох эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэх”, “...Эрүүдэн шүүгдсэний улмаас хохирсон хохирогчид хангалттай хэмжээний нөхөн олговор болон нөхөн сэргээх үйлчилгээ авах нөхцөлийг хангах... нөхцөлийг бүрдүүлэх” тухай зөвлөмжийг 2015 онд өгсөн болно.¹⁹

Мөн НҮБ-ын Хүний эрхийн хороо ИУТЭОУП-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ЗГ-ын 6 дахь удаагийн ээлжит тайланг хэлэлцээд

¹³ CAT, General Comment No3, CAT/C/GC/3, para 1

¹⁴ CAT, General Comment No3, CAT/C/GC/3, para 6

¹⁵ CAT, General Comment No3, CAT/C/GC/3, para 26

¹⁶ CAT, General Comment No3, CAT/C/GC/3, para 5

¹⁷ Association for the Prevention of Torture and Convention against Torture Initiative, Guide on anti-torture legislation, 2016, p.53

¹⁸ Manfred Novak, Report by Special Rapporteur on Torture and other cruel, inhuman or degrading treatment or punishment: Mission to Mongolia, E/CN.4/2006/6/Add.4, 2005, para 55 (i)

¹⁹ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг II цикл, 2015 он, Чех Улс 108.72, Герман 108.126

“...хоширогчдод бүрэн нөхөн сэргэх боломжийг оролцуулан хохирлоо барагдуулах боломжтой байх...” тухай зөвлөсөн.²⁰

ЭШЭХ-оос Монгол Улсын хоёр дахь удаагийн илтгэлд өгсөн дүгнэлт зөвлөмжид “...Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд бие махбодийн болон сэтгэл санааны хохирлын аль алинд нөхөн олговор олгох болсныг тэмдэглэхийн сацуу эрүү шүүлт, зүй бусаар харьцсаны улмаас хохирсон хохирогчийг зохих ёсны нөхөн сэргээх, нөхөн олговрыг оролцуулан хохирол барагдуулах талаар хууль байхгүйд Хороо санаа зовниж байна (2 ба 14-р зүйл)” гэдгээ илэрхийлж, “шударга бусаар саатуулагдсан хохирогчдыг цагаатгах болон нөхөн олговор олгох баталгаагаар хангах”, “Оролцогч улс эрүү шүүлт болон зүй бус харьцсаны улмаас хохирсон хохирогч шударга, зүй ёсны нөхөн олговор авах, нөхөн сэргээлгэх эрхтэй болохыг хуулиар баталгаажуулах, үүнийг бодитой болгох санг байгуулах...”-ыг тус тус зөвлөсөн байна.²¹

2.3. Нөхцөл байдлын үнэлгээ

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 14 дэх хэсэгт “...бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх...” эрхийг баталгаажуулсан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах тухай харилцааг зохицуулсан. Гэвч хууль бус үйлдэл хийсэн албан тушаалтныг тоочсон нь эрүүдэн шүүх гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ЭШЭК-ийн дагуу илүү өргөнөөр тодорхойлодогтой зөрчилдөж, улмаар хуулийн тодорхойлолтод байхгүй гэсэн үндэслэлээр хохирлоо нэхэмжлэх эрхэд хязгаарлалт болж болзошгүй байна. Мөн эрүүдэн шүүлтэд өртсөн хохирогчийн сэтгэл санааны

хохирлыг барагдуулах асуудлыг Иргэний хуульд заасан журмыг баримтлахаар тогтоосон нь учир дутагдалтай юм.²² Шүүхийн практикаас үзэхэд сэтгэл санааны хохирлыг “нэхэмжлэгч буюу иргэн өөрөө нотолж чадаагүй” гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгодог нийтлэг жишиг тогтсоны зэрэгцээ бусад хүнлэг бус харьцааны улмаас хохирсон хохирогчийн хохирлыг барагдуулах зохицуулалт байхгүй байна.

Монгол Улсын ЗГ-ын Тусгай сангийн тухай хуулиар “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”-г байгуулсан бөгөөд Эрүүгийн хуулийн “эрүүдэн шүүх”-тэй холбоотой 10.1, 11.1, 21.12 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох харилцааг зохицуулсан.²³ Харин Эрүүгийн хуулийн 11.4, 11.6 буюу эрүүдэн шүүж хүний эрүүл мэндэд хүндэвтэр, хөнгөн гэмтэл учруулсан гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр төлөх асуудал тусаагүй байна. ЭШЭК-оор хүлээсэн үүрэг бол эрүүдэн шүүгдсэн хохирогчид үзүүлэх нөхөн төлбөрийг ялгамжтай авч үзэхгүй байх, бүх хохирогчдод шударга, зохих ёсны нөхөн төлбөр өгөх явдал юм.

ЭШЭК-ийн дагуу хохирогч нь эрүүдэн шүүсэн этгээдийг тогтоосон эсэх, мөрдөн шалгаж, шүүгдэж байгаа эсэхээс үл хамааран хохирлоо нэхэмжлэх эрх үүсэх ёстой ч манай хуулийн дагуу хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдохоор байгаа²⁴ нь эрүүдэн шүүсэн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэж дууссаны дараа л хохирлоо барагдуулах эрх үүсэхээр байна. Мөн Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого л байхаар заасан нь ЭШЭК-ийн зарчимд үл нийцнэ. Үүний зэрэгцээ нөхөн төлбөрийн дээд хэмжээг

²⁰ UN Human Rights Committee, Concluding Observations on the sixth periodic report of Mongolia, 2017, CCPR/C/MNG/CO/6, para. 21

²¹ UN CAT, Concluding Observations on the second periodic report of Mongolia, 2016, CAT/C/MNG/CO/2, para.14 (d), 39, 40

²² УИХ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он, www.legalinfo.mn, 45.4 дүгээр зүйл

²³ УИХ, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2006 он, www.legalinfo.mn, 213.2 дугаар зүйл

²⁴ УИХ, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 2006 он, www.legalinfo.mn, 213.3 дугаар зүйл

зааж өгсөн бөгөөд нас барсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин, эрүүл мэндэд хүнд гэмтэл учирсан бол 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөг байхаар тогтоосон нь ЭШЭК-д заасан хохирлыг бүрэн барагдуулах зарчимтай үл нийцнэ.²⁵

Монгол Улсын ЗГ НҮБ-ын ХЭЗ-ийн зөвлөмжийг хэрэгжүүлсэн дунд хугацааны тайлангийн 2.12 дахь хэсэгт “Хууль сахиулахын их сургуулиас эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчдод учирсан хохирлын хэмжээ тооцох аргачлалыг боловсруулан холбогдох газраас санал авч саналын хамт ХЗДХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар ирүүлсэн боловч уг аргачлалыг батлах эрх бүхий субъект тодорхойгүйн улмаас... саналаа хүргүүлээд байна” гэжээ. Хэдий аргачлал боловсруулах алхам хийсэн нь сайшаалтай хэдий ч ажил хэрэг болгох тал дээр анхаарах шаардлагатай.

2.4. Зөвлөмж

- Эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус харьцааны улмаас хохирсон хохирогчдын хохирлыг шударгаар барагдуулах, бүрэн нөхөн сэргээх асуудлыг тусгасан цогц эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх;

- Хохирол барагдуулах тогтолцоог бүрдүүлэхдээ эрхийг сэргээх, нөхөн олговор олгох, нөхөн сэргээх, төрийн хүлээх хариуцлага болон тухайн үйлдэл дахин давтагдахгүй байх асуудлыг багтаан авч үзэх;
- Эрүүдэн шүүгдсэний улмаас тухайн хүнд эрүүл мэнд, сэтгэл санааны хувьд арилшгүй толбо, эмгэг шинж үүсдэг тул нөхөн олговор олгохоос гадна нөхөн сэргээх үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай, үнэ төлбөргүй үзүүлэх замаар хохирлын хор аюулыг бууруулдаг жишгийг нэвтрүүлэх;
- Эдийн бус хохирлыг үнэлэх, тооцох аргачлалыг нэн даруй батлан гаргах, үнэлгээ хийх мэргэжлийн байгууллагуудад эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг үнэлэх мэргэшсэн чиг үүрэг бүхий шинжээч эсхүл энэ чиглэлийн албыг байгуулж, ажилтнуудыг мэргэшүүлэн ажиллуулах замаар хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх;
- Эрүүдэн шүүгдсэний улмаас бий болсон эдийн болон эдийн бус сэтгэл санаа бие махбодийн хохирлыг тооцох, үнэлэх, олгох, нөхөн сэргээх зардлыг төрөөс шууд гаргах, уг зардлыг буруутай этгээдээс нөхөн гаргуулах цогц тогтолцоо бий болгох;
- Цагдан хоригдсон хугацааг цагаар тооцох механизмыг бий болгох.

²⁵CAT, General Comment No3, CAT/C/GC/3

ГУРАВ. ХАРААТ БУС МӨРДӨН ШАЛГАХ АЛБА

ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан, Улаанбаатар эрдэм их сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн багш Б.Галдаа, МХХ-ны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Ц.Жаргалан

3.1. Олон улсын хэм хэмжээ

ЭШЭЖ-ийн оролцогч улс нь эрүүдэн шүүсэн эсхүл зүй бус харьцааны талаар гаргасан гомдлыг түргэн шуурхай, үр дүнтэй мөрдөн байцаах, шалгахыг баталгаажуулахыг шаарддаг.²⁶ Мөрдөн шалгах байгууллага нь чадавхтай, хөндлөнгийн, бие даасан байх ёстой. ЭШЭЖ-ийн 12-р зүйлийн дагуу эрүүдэн шүүсэн гэж үзэх хангалттай үндэслэл байвал мөрдөн шалгах ажиллагааг эрх бүхий байгууллага шударга, шуурхай явуулах үүрэг хүлээсэн. Мөн хараат бус мөрдөн шалгах байгууллагад хамаарах чухал эх сурвалж бол Эрүүдэн шүүх болон бусад хүнлэг бус харьцааг үр дүнтэй мөрдөн шалгах, баримтжуулах гарын авлага (Истанбулын протокол) юм.

3.2. НҮБ-ын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмж

Монгол Улс НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны үеэр дараах зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх амлалт өгсөн. Үүнд, чадавхтай, хөндлөнгийн, бие даасан байх шаардлагад нийцүүлэх, хууль сахиулах алба хаагчийн үйлдэлд үр нөлөөтэй мониторинг хийх механизмыг бий болгох, эрүүдэн шүүсэн бүх үйлдлийг мөрдөн шалгах ажиллагааг сайжруулах, энэ хүрээнд ял шийтгэлгүй үлдэхтэй үр дүнтэй тэмцэх мөрдөн шалгах механизмыг бий болгох, эрүүдэн шүүсэн тохиолдол нэг бүрийг мөрдөн шалгах хараат бус механизмыг байгуулах, эрүүдэн шүүсэн, хууль бус харьцсан бүх этгээдийн үйлдлийг үл тэвчиж, мөрдөн шалгах, цагдаагийн алба хаагчийн үйлдсэн эрүүдэн шүүлт, хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг гутаан доромжилсон

үйлдлийг мөрдөн шалгах хараат бус механизмтай болох, эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хүнлэг бус харьцсан талаарх бүх гомдол, мэдээллийг хараат бус байгууллага нягт нямбай мөрдөн шалгах, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх, бүх хэргийг түргэн шуурхай, нягт нямбай мөрдөн шалгах, эрүүдэн шүүх, цагдаагийн хэрцгий харьцаа, хууль бусаар цагдан хорих тохиолдол нэг бүрийг мөрдөн шалгах шүүхийн болон бусад механизмыг бий болгох, ял шийтгэлгүй үлдэхтэй тэмцэх зорилгоор эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий харьцсан тохиолдол бүрийг үр дүнтэй, хараат бусаар мөрдөн шалгах, эрүүдэн шүүсэн хэрэгт ял шийтгэгдэхгүй байхтай тэмцэх.²⁷

НҮБ-ын Хүний эрхийн хороо дүгнэлт зөвлөмждөө “эрүүдэн шүүх” нь хэрэг хүлээлгэх арга хэрэгсэл болсоор байгаа, эрүүдэн шүүсэн этгээд ял шийтгэгдэхгүй үлдсээр байгаад санаа зовиныхын зэрэгцээ эрүүдэн шүүх гэмт хэргийг мөрдөн шалгах албаны хараат бус байдал хангагдахгүй байна гэж үзсэн.²⁸ Хороо эрүүдэн шүүх бүх гэмт хэргийг түргэн шуурхай, нягт нямбай мөрдөн шалгах, эрүүдэн шүүх гэмт хэрэгт холбогдсон этгээдийг мөрдөн шалгаж, буруутай нь тогтоогдвол тохирох ял шийтгэл оногдуулахыг зөвлөсөн байна.²⁹

ЭШЭЖ дүгнэхдээ УЕПГ-ын Мөрдөн байцаах албыг татан буулгаж, чиг үүргийг АТГ, ЦЕГ-ын Мөрдөн шалгах албанд шилжүүлсэн нь ашиг сонирхлын зөрчил үүсгэх, мөрдөн шалгах ажлын

²⁶ Эмнести интернэшнл, Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь: Үйл ажиллагааны гарын авлага (АСТ 40/001/2203), УБ хот 2004 он, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан доромжлох, шийтгэх, хэргийг баримтжуулах болон тийм гэмт хэрэгт үр дүнтэй мөрдөн шалгалт хийх зарчим (НҮБ-ын Ерөнхий ассамблейн тогтоол, 55/89, 2000.12.04), Хавсралт 10, 292-р тал

²⁷ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I, II цикл, 2010 он, 2015 он, Шинэ Зеланд 84.3, Герман 84.97, Чех Улс, 108.72, Франц Улс 108.73, Австри, 108.75, Тимор Лист, 108.76, Швейцар, 108.77, Швед 108.78, Итали, 108.79, Канад 108.81, Герман, 108.126

²⁸ UN Human Rights Committee, Concluding Observations on the sixth periodic report of Mongolia, 2017, CCPR/C/MNG/CO/6, para. 21

²⁹ UN Human Rights Committee, Concluding Observations on the sixth periodic report of Mongolia, 2017, CCPR/C/MNG/CO/6, para. 22

үр нөлөөг бууруулах, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзахад хүргэж болзошгүй. Хороо “төрийн албан хаагч, цагдаагийн үйлдсэн эрүүдэн шүүх, хүнлэг бус бусад харьцаатай холбоотой бүх хэргийг нэн даруй, үр дүнтэй, хөндлөнгийн байдлаар шалгадаг хараат бус байгууллагаар мөрдөн шалгадаг байх, мөрдөгч, хэрэгт холбогдсон этгээд хоорондоо байгууллагын болон эрх мэдлийн холбоогүй байх, мөрдөн шалгах явцад албан ажлаас нь чөлөөлөх, шүүхээр нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй байх, бүх мэдүүлгийн өрөөг аудио, видео бичлэг хийх төхөөрөмжөөр хангах, бичлэгийг эрүүдэн шүүх болон хэм хэмжээ зөрчсөн эсэхийг тогтооход ашиглах, шүүхэд нотлох баримтаар тооцох, энэ нь яллагдагч, түүний өмгөөлөгчид нээлттэй байх, үүний зардлыг яллагдагчаар төлүүлдэггүй байхыг зөвлөсөн.³⁰

3.3. Нөхцөл байдлын үнэлгээ

Эрүүдэн шүүсэн тохиолдлыг хараат бусаар мөрдөн байцаах албыг УЕПГ-ын дэргэд 2002 онд байгуулан ажиллуулж байсныг 2014 оны 1-р сард татан буулгасан. Тус албаны чиг үүргийг ЦЕГ-ын даргын 2014 оны А/95 дугаар тушаалаар байгуулсан Мөрдөн байцаах газрын Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэргийг мөрдөх хэлтэст шилжүүлсэн байна. Үүний дараа 2017 оны 7-р сарын 1-ээс үйлчилж эхэлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 6.1.4-өөр прокурор харьяаллыг тогтоохоор зааж, УЕП-ын 2017 оны А/67 тушаалаар АТГ-ын мөрдөгч цагдаагийн байгууллагын алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн, ТЕГ-ын мөрдөгч цагдаагийн байгууллага, авлигатай тэмцэх байгууллагын алба хаагчийн үйлдсэн гэмт хэргийн, ЦЕГ-ын Мөрдөн байцаах албан шүүгч, прокурор, авлигатай тэмцэх газрын алба хаагчийн үйлдсэн гэмт хэрэг, тагнуулын байгууллагын алба хаагчийн үйлдсэн гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг шалгах аар харьяаллыг тогтоосон байна.³¹

³⁰ UN CAT, Concluding Observations on the second periodic report of Mongolia, 2016, CAT/C/MNG/CO/2, para. 16, 18

³¹ Монгол Улсын ерөнхий прокурорын тушаал, А/67, Гэмт

УЕПГ-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба 2002-2012 оны хооронд нийт 5,979 гомдол, мэдээлэл хүлээн авсны 1,276 буюу 21,3 хувь нь, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан 3,080 хэргийн 195 буюу 6,3 хувь нь эрүүдэн шүүх хууль бус ажиллагаанд хамаарах хэрэг, гомдол байсан байна.³² Тус алба нь 2002-2014 онд гэмт хэргийн улмаас бусдад учирсан нийт 3,541,798.4 сая төгрөгийн хохирлыг барагдуулж, 6,171,861 сая төгрөгийн хөрөнгийг битүүмжилжээ.³³

Гэвч 2014 онд тус алба татан буугдсанаас хойш эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах, илрүүлэх үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байгаа болохыг ХЭҮК-ын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18-р илтгэлд тодорхой тоо баримтаар дүгнэсэн.³⁴

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс гаргасан эрүү шүүлт тулгах гэмт хэргийг 2017, 2018 онд хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллээс үзэхэд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2017, 2018 онд Эрүүгийн хуулийн (2002 он) 251 дүгээр зүйл, Эрүүгийн хуулийн (2015 он) 21.12 дугаар зүйлээр хэрэг хянан шийдвэрлээгүй байна.³⁵ Гэтэл Хууль зүй дотоод хэргийн сайд Ц.Нямдорж хэвлэл мэдээллийн хэрэгслээр Монгол Улсад эрүүдэн шүүлт бодитой явагдсан гэдгийг албан ёсоор хүлээгээд байгаа билээ.³⁶

хэргийн талаарх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяалал тогтоох тухай, УБ хот, 2017 он, Хавсралт

³² Хүний эрхийн Үндэсний комисс, Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдаж буй асуудал ба бие даасан хараат бус байгууллага, Б.Галдаа, “Хүний эрх сэтгүүл”, 2015/01, 20-р тал

³³ Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дах Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дах илтгэл, 2019 он, www.nhrct.gov.mn, 82-р тал

³⁴ Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дах Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дах илтгэл, 2019 он, www.nhrct.gov.mn, 77-85-р тал

³⁵ Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Улс дах Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дах илтгэл, 2019 он, www.nhrct.gov.mn, 82-р тал

³⁶ Ц.Нямдорж: С.Зоригийн амь нас хохирсон хэрэгтэй холбогдуулан эрүүдэн шүүлт явагдсан. Б.Содномдаржаа, Т.Чимгээ нарын ар гэрийнхнээс уучлал гуйж байна, <https://ikon.mn/n/1j0x> (2019.05.16)

3.4. Зөвлөмж

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2002 оны тогтоолоор “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг гутаан доромжлох, шийтгэх хэргийг баримтжуулах болон тийм гэмт хэрэгт үр дүнтэй мөрдөн шалгалт хийх зарчим”-ыг баталсан. Монгол Улс хараат бусаар мөрдөн шалгах институци бий болгох чиглэлээр тодорхой хүчин чармайлт тавьж ирсэн хэдий ч энэ асуудалд тодорхой ахиц гарсангүй. Иргэний нийгмийн байгууллагаас тодорхой байгууллага, бүтцийн талаар санал гаргахаас илүүтэй байгууллага байгуулахдаа баримтлах ерөнхий зарчмын талаар санал болгож байна. Юуны түрүүнд хараат бус мөрдөн шалгах албанд тусгай субъектийн үйлдсэн бүх хэргийг бус зөвхөн эрүүдэн шүүх, зүй бус харьцаатай холбоотой мөрдөн шалгах эрхийг олговол тус алба нь дагнасан, мэргэшсэн, цомхон байх боломжтой. Энэ албыг НҮБ-ын зарчмын дагуу дараах шаардлагад нийцүүлэн нэн даруй байгуулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Эрүүдэн шүүхтэй холбоотой гомдол мэдээллийг түргэн шуурхай, үр дүнтэй мөрдөн байцаалт явуулах боломж, нөхцлөөр хангагдсан байх;
- Мөрдөгчид нь эрүүдэн шүүсэн хэрэгт холбогдсон этгээд, эсхүл түүний ажилладаг байгууллагаас хараат бус, бие даасан, чадавхтай байх;
- Хараат бус эмнэлгийн болон бусад шинжээч мөрдөн шалгах явцад оролцох эрхтэй байх, эмнэлгийн мэргэжилтэн нь мөрдөн шалгах ажиллагаанд оролцохдоо мэргэжлийн ёс зүйн

хэм хэмжээг мөрдөх бөгөөд аливаа үзлэгийг хийхдээ мэдээлэл өгсний үндсэн дээр зөвшөөрөл авдаг байх, үзлэгийг төрийн албан хаагч, хамгаалалтын ажилтны оролцоогүй явуулах, үзлэгийн талаар нягт нямбай тайлан бичих үүрэгтэй байх;

- Мөрдөн шалгах ажлыг мэргэжлийн өндөр түвшинд явуулах, үр дүнг нийтэд мэдээлэх
- Мөрдөн шалгах явцдаа шаардлагатай бүх мэдээллийг олж авах эрх, үүрэгтэй байх;
- Мөрдөн шалгах ажиллагаа явуулах техникийн болон санхүүгийн эх үүсвэрээр бүрэн хангагдсан байх;
- Эрүүдэн шүүх, зүй бус харьцсан гэх бүх мэдээллийг шалгах үүрэгтэй байх;
- Мөрдөн шалгах явцдаа гэмт хэрэгт холбогдсон албан тушаалтнаар нотлох баримт гаргуулахыг шаардах эрхтэй байх;
- Шаардлагатай тохиолдолд албан тушаалтныг оролцуулан бүх гэрчийг дуудах эрхтэй байх;
- Эрүүдэн шүүхийн хохирогч, гэрч, мөрдөн шалгаж буй этгээд, гэр бүлийн гишүүдийг заналхийлэх, айлган сүрдүүлэх, хүчирхийлэлд өртөхөөс хамгаалах үүрэгтэй байх;
- Эрүүдэн шүүх явцад шууд буюу шууд бусаар хамтран оролцсон байж болох этгээдийг эрх мэдэл, албан тушаалаас эргүүлэн татах хүсэлт гаргах эрхтэй байх;
- Эрүүдэн шүүлтийн хохирогч, түүний өмгөөлөгчийг мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой бүх мэдээлэл, баримттай танилцах боломжоор хангах зэрэг болно.

ДӨРӨВ. ЭРҮҮДЭН ШҮҮХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Монголын Эмнести Интернэшнл ТББ-ын Гүйцэтгэх захирал Б.Алтантуяа, Монголын Эмнести Интернэшнл ТББ-ын Кампанит ажил хариуцсан зохицуулагч Г.Амарзаяа

4.1. Олон улсын хэм хэмжээ

Аливаа хэлбэрээр баривчлагдан саатуулагдсан, эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн эрхийг хамгаалах гол арга зам бол хорих, цагдан хорих газруудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих явдал юм. Сүүлийн 20-оод жил бүх төрлийн хорих газарт хамааралтай олон улсын хүний эрхийн хэм хэмжээ хянагдан улам тодорхой болсноос гадна 2002 оны 12 дугаар сард НҮБ-ын Ерөнхий Ассамблей эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх зорилгоор НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг³⁷ баталж, оролцогч улсад хорих, цагдах хорих газруудад хяналт шалгалт хийх тодорхой эрх бүхий, хараат бус байгууллага байгуулахыг үүрэг болгосон³⁸ байна. ЭШЭЖ-ийн Нэмэлт протоколын дагуу үр нөлөөтэй Урьдчилан сэргийлэх үндэсний механизм (УСҮМ) нь дараах элементийг агуулсан байх ёстой. Үүнд:

1. Хүлээх үүрэг, бүрэлдэхүүн, байгууллага тогтолцооны хувьд **хараат бус байх**
2. Хүний болон санхүүгийн **хангалттай нөөцтэй байх**
3. УСҮМ-ын бүрэлдэхүүн **олон талт байдлыг хангасан байх**
4. Бүх төрлийн хорих газарт нэвтрэх, хувь хүнд хүрэх **эрх мэдэл, хамгаалалтаар хангагдсан байх**

Мөн тус механизмыг байгуулах явцыг нээлттэй ил тод байлгах, оролцоог хангах, гишүүд болоод уг механизмыг бүрдүүлэх хүний нөөцөд тавих

³⁷ <https://www.ohchr.org/en/professionalinterest/pages/opcat.aspx>

³⁸ ЭШЭЖ-ийн Нэмэлт Протокол. 3 дугаар зүйл. "Оролцогч улс бүр үндэсний түвшинд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлаас урьдчилан сэргийлэх (цаашид "үндэсний урьдчилан сэргийлэх байгууллага" гэнэ) зорилгоор хорих газар тогтмол очиж байх нэг буюу хэд хэдэн байгууллага байгуулах, томилох, эсхүл ийм байгууллагад дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ."

тодорхой шалгууртай байх, урьдчилан сэргийлэх механизмаас гарах зөвлөмжийн хүчин чадал, хэрэгжих байдал, иргэний нийгмийн байгууллага болон УСҮМ-ын хамтын ажиллагаа, УСҮМ-ын олон улсын түвшин дэх харилцаа зэргийг цогц анхаарч зохицуулах нь зүйтэй.

4.2. НҮБ-ЫН ЗӨВЛӨМЖ

НҮБ-ын Эрүү шүүлтийн асуудлаарх Тусгай илтгэгч Манфред Новак манай улс дах эрүү шүүлтийн нөхцөл байдалтай танилцсан илтгэлээ НҮБ-ын Эдийн засаг нийгмийн зөвлөлийн 2005 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 62 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж,³⁹ Монгол улсын Засгийн газарт зөвлөмж⁴⁰ хүргүүлсэн.

Түүнээс гадна Монгол Улсад хорих байгууллагуудын даац хэтэрсэн, цагдан хорих байруудад тогтмол, хараат бус хяналт тавихгүй байгаад НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо тус тус харамсаж байгаагаа илэрхийлж 2011 оны 3 дугаар сарын 11-ээс 4 дүгээр сарын 1-ний өдөр хуралдсан НҮБ-ын Хүний эрхийн хорооны 101 дүгээр чуулганаар "Оролцогч улс цагдан хорих байранд хяналт тавих бие даасан механизм байгуулах шаардлагатай байна. Мөн хорих ангиудын даацыг хэтрүүлэхгүй байхад анхаарч холбогдох арга хэмжээ авах, НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийг баримтлах хэрэгтэй" гэсэн зөвлөмж өгчээ.

Хүний эрхийн төлөв байдлын Ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг нь НҮБ-ын гишүүн 193 орны хүний эрхийн төлөв байдлыг 4 жил тутам дүгнэн хэлэлцэх механизм бөгөөд Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлыг НҮБ-ын Хүний

³⁹ НҮБ-ын Эдийн засаг нийгмийн зөвлөлийн 2005 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 62 дугаар хуралдаан. E/CN.4/2006/X/Add.X тогтоол

⁴⁰ E/CN.4/2006/6/Add.4.Зөвлөмж (g), Зөвлөмж (o) <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G05/167/32/PDF/G0516732.pdf?OpenElement>

эрхийн Зөвлөлийн 47 гишүүнээс бүрдсэн Ажлын Хэсгийн хуралдаанаар Женев хотноо 2010 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр хэлэлцэж, гишүүн улсууд нийт 129 зөвлөмж өгснөөс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлах,⁴¹ хууль хяналтын байгууллага, хорих байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих үр дүнтэй механизм хэрэгжүүлэх⁴² талаарх зөвлөмжийг Мексик, Шинэ Зеланд, Испани улсаас өгсөн байна.

Монгол Улсын Засгийн газар хоёрдугаар илтгэлээ 2015 оны 2 дугаар сард хүргүүлж, тус оны 5 дугаар сард хэлэлцүүлэн хамгаалсан. Нийт 64 улсаас 164 зөвлөмж өгснөөс Монгол Улсын Засгийн газар 150 зөвлөмжийг хүлээн авч, биелүүлэхээр амлалт өгсөн. Зохих чадамжтай, нөөц бололцоотой эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх механизмыг даруй бий болгох, бэхжүүлэх талаарх зөвлөмжийг⁴³ Чех, Итали улсаас өгсөн байна.

2016 оны 9 дүгээр сарын 5-нд Эрүүдэн шүүхийн эсрэг хороо, олон улсын хамтын нийгэмлэгээс өгсөн өмнөх зөвлөмжүүдийг⁴⁴ яаралтай хэрэгжүүлэхийг шаардахын зэрэгцээгээр хорих, цагдан хорих төвийн нөхцөлийг олон улсын хэм хэмжээ тухайлан НҮБ-ын хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм (Нельсон Мандела дүрэм)⁴⁵-д нийцүүлэх, аливаа хэлбэрийн хорих байруудад тогтмол хяналт тавих, энэ механизмыг ХЭҮК хэрэгжүүлэх, ХЭҮК-ын өнөөгийн эрх мэдэл, нөөцийг нэмэгдүүлэх, ХЭҮК-ын бие даасан, хараат бус байх боломжийг бүрдүүлэх гэсэн зөвлөмжүүдийг⁴⁶ тус тус өгч байжээ.

Үүнээс гадна Эрүүдэн шүүхээс урьдчилан

сэргийлэх механизмыг ХЭҮК хэрэгжүүлэхээр зааж, ХЭҮК-ийн эрх хүрээг өргөтгөх хуулийн төслийг боловсруулахдаа үйл ажиллагаагаа явуулахад хүрэлцэхүйц санхүүгийн болон хүний шаардлага хангасан нөөцтэй байхад анхаарахыг зөвлөжээ. Мөн Парисын зарчимд заагдсан нээлттэй, ил тод, олон талт оролцоог хангасан томилгоо хийх замаар урьдчилан сэргийлэх механизмын бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулахыг үүрэг болгосон.⁴⁷

4.3. Нөхцөл байдлын үнэлгээ

Монгол улс 2014 оны 12 дугаар сарын 11-нд ЭШЭК-ийн Нэмэлт протоколыг соёрхон баталж, НҮБ-ын хүний эрхийн механизмуудаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж эхэлсэн ч, ЭШЭК-ийн Нэмэлт протоколын дагуу УСҮМ байгуулах үүргээ өнөөг хүртэл биелүүлээгүй байна. Ингэснээр хорих, цагдан хорих газарт гарч буй эрүү шүүлт, зүй бус харьцааг нуун далдлах, эрүүдэн шүүхээс ангид байх эрх өргөн хүрээнд зөрчигдөхөд хүргэх нөхцөлийг бүрдүүлж байна. ХЭҮК нь Монгол Улс дахь хүний эрх чөлөөний талаарх 16 дахь илтгэлдээ эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх механизмыг яаралтай бий болгох талаар зөвлөмж хэд хэдэн удаа өгсөн ч өнөөг хүртэл үр дүнд хүрээгүй байна⁴⁸ хэмээн дурдсан байдаг. 2018 онд ХЗДХЯ-ны дэргэд ХЭҮК-ын тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хэсгийг дахин байгуулж, хуулийн төслийг боловсруулж эхлээд байна.

ХЭҮК-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд УСҮМ бий болгох тусгай бүлэг гарган ажиллаж байгаа нь сайшаалтай боловч, төсөлд шинжилгээ хийж үзвэл УСҮМ үр дүнтэй ажиллахад хэд хэдэн дутагдалтай тал ажиглагдаж байна. Үүнд:

а/ хүлээх үүрэг, бүрэлдэхүүн, тогтолцооны хувьд хараат бус байх

Тус хуулийн төслийн “3.1.2. дахь хэсэгт “эрүү

⁴¹ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I цикл, 2010 он, А/HRC/16/5, Мексик 84.2, Шинэ Зеланд 84.3, Испани-84.4

⁴² НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I цикл, 2010 он, А/HRC/16/5, Шинэ Зеланд 84.3

⁴³ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг II цикл, 2010 он, 2015 он, А/HRC/30/6, Чех-108.7, Итали-108.79

⁴⁴ UN Committee against Torture, CAT/C/MNG/CO/1, para. 16

⁴⁵ https://www.unodc.org/pdf/criminal_justice/UN_Standard_Minimum_Rules_for_the_Treatment_of_Prisoners.pdf

⁴⁶ UN Committee against Torture, CAT/C/MNG/CO/2, 2016, para 20(c), 33

⁴⁷ UN Committee against Torture, CAT/C/MNG/CO/2, 2016, para 34 (a), (b)

⁴⁸ ХЭҮК-ын Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл

шүүлтээс урьдчилан сэргийлэх” гэж эрүү шүүлт тулгах болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхээс урьдчилан сэргийлэх хараат бус, бие даасан цогц үйл ажиллагааг” гэж тусгасан нь хэт ерөнхий, цогц үйл ажиллагаанд юуг багтааж ойлгох нь тодорхой бус байна.

Мөн хуулийн төслийн 33.1.1-д ““бүх газарт” гэдгийг хорих байгууллага, цагдан хорих анги, түр болон албадан саатуулах газар, хүүхдийн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон ахмадын асрамжийн газар, сургуулийн дотуур байр, албадан эмчилгээний байр, дүрвэгсэдийн байр, цэргийн сахилгын байр, хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь түр саатуулах байр зэрэг өргөн утгаар ойлгоно” хэмээсэн нь ЭШЭХ, Урьдчилан сэргийлэх дэд хорооны тодорхойлолтод бүрэн нийцээгүй бөгөөд зарим газар орхигдох эрсдэл байна.

б/ Хүний болон санхүүгийн хангалттай нөөцтэй байх талаар

Хуулийн төслийн 5.2-т “Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагыг оролцуулж болно” гэж заасан нь оролцуулах эсэх тухайн байгууллагын үзэмжээр шийдэгдэхээр болжээ. Энэ нь иргэний нийгмийн байгууллагад байгаа нөөц бололцоог эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үйл хэрэгт татан оролцуулах, хүний болоод санхүүгийн нөөцийг үр дүнтэй ашиглах боломжийг үгүйсгэж буй хэрэг юм.

в/ УСҮМ-ийн бүрэлдэхүүн олон талт байдлыг хангасан байх талаар

Мөн хуулийн төслийн 12.1.1-т Комиссын гишүүнд нэр дэвшигч нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай байх, хуулийн төслийн 32.1-д Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнээр хууль зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай байх хэмээн

тусгасан нь зөвхөн хуульч хүн л хүний эрх хамгаалдаг, эрүүдэн шүүхтэй тэмцдэг хэмээн ташаа ойлгогдож болзошгүй байна. Олон улсын сайн туршлага, үр дүнтэй УСҮМ байгуулахтай холбоотой зарчим,⁴⁹ энэ чиглэлээр өгсөн зөвлөмжид УСҮМ-д ажиллах бүрэлдэхүүнд эмч, эмнэлгийн ажилтан, сэтгэл зүйч, инженер гэх мэт бусад мэргэжлийн, эсхүл үндэсний цөөнх гэх мэт хүн амын тодорхой бүлгийн оруулдаг бодит хувь нэмрийг онцлон тэмдэглэсэн байдаг.

г/ Бүх төрлийн хорих газарт нэвтрэх, хувь хүнтэй уулзах эрх мэдэл, хамгаалалтаар хангагдсан байх

Хуулийн төслийн 18.1.2, 26.1, 34.1-т зааснаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн нь бүх төрлийн хорих газарт нэвтрэх, хувь хүнтэй уулзах эрх мэдлээр хангагдсан байхаас гадна 35.4-т уг гишүүний зөвлөмжийг биелүүлээгүй албан тушаалтанд оногдуулах хариуцлагыг тусгаж өгсөн нь үр дүнтэй урьдчилан сэргийлэх механизм байгуулах шалгуурт нийцсэн зохицуулалт мэт харагдаж байгаа боловч гишүүний эрх мэдэл зөвхөн хариуцлага тооцуулах санал гаргах төдийгөөр хязгаарлагдаж байгаа нь явцуу болжээ. Ялангуяа эрүүдэн шүүх нөхцөл байдал үүссэн үед яаралтай таслан зогсоох, нөхцөл байдлыг сайжруулах арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай үед уг гишүүний эрх мэдэл хүрэлцэхгүй гэсэн үг юм.

Уг хуулийн төслийн 11.1-т Комиссын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай гэмт хэргийн нөхцөл байдал, түүний шалтгаан нөхцөлийн талаар статистик мэдээллийг прокурорын байгууллагаас гаргуулж авах эрхтэй гэж заасан нь мэдээлэл авах хүрээг зөвхөн энэ хоёр төрлийн мэдээллээр хязгаарлах, хэрвээ өөр мэдээлэл шаардлагатай бол энэ хуулийн 18.1.2-ыг нэмж дурдан хэрэглэх ойлгомжгүй нөхцөл үүсгэх эрсдэлтэй байна.

⁴⁹ Establishment and Designation of National Preventive Mechanisms
Website: www.apt.ch

4.4. Зөвлөмж

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг ХЭҮК-ын дэргэд байгуулахдаа дараах шаардлагад нийцүүлэх. Үүнд

Хүлээх үүрэг, бүрэлдэхүүн, байгууллага тогтолцооны хувьд хараат бус байх

- “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” гэж ЭШЭК-ийн нэмэлт протоколд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх” гэж өөрчлөн найруулах;
- ХЭҮК-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 33.1.1—ийг ЭШЭХ, Урьдчилан сэргийлэх дэд хорооны тодорхойлолтод бүрэн нийцүүлэх, “шүүхийн болон захиргааны байгууллага, бусад эрх бүхий байгууллагын тушаалаар төрийн болон хувийн газар харуул хамгаалалтанд байлгах” гэсэн санааг нэмж оруулах.

Бүрэлдэхүүний хувьд хараат бус байх

- Томилгоотой холбоотой хурлын тэмдэглэлийг нийтэд ил болгох, томилгооны сонсгол явуулах зэргээр олон нийт хяналт тавих боломжийг өргөтгөсөн зохицуулалтыг нэмж тусгах.

Хүний болон санхүүгийн хангалттай нөөцтэй байх

- Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагыг

оролцуулж, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмийг ХЭҮК дээр нэмэх нь 2-3 төрийн бус байгууллага хэрэгжүүлэхийг хуулиар баталгаажуулах.

УСҮМ-ын бүрэлдэхүүн олон талт байдлыг хангасан байх

- Олон улсад байгаа сайн туршлага, үр дүнтэй УСҮМ байгуулахтай холбоотой зарчим, энэ чиглэлээр өгсөн зөвлөмжид тулгуурлан УСҮМ-ын бүрэлдэхүүнд эмч, эмнэлгийн ажилтан, сэтгэл зүйч, инженер гэх мэтээр бусад мэргэжлийн, эсхүл үндэсний цөөнх гэх мэт ялгаатай байдалтай хүмүүсийг оролцуулах зэргээр олон талт байдлыг хангаж өгөх.

Бүх төрлийн хорих газарт нэвтрэх, хувь хүнд хүрэх эрх мэдэл, хамгаалалтаар хангагдсан байх

- Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүх төрлийн хорих газарт нэвтрэх, хувь хүнтэй уулзах, шаардлагатай мэдээллээ гаргуулан авах болон бусад эрх мэдлийг өргөн хүрээнд тодорхойлж өгөх, гаргасан зөвлөмж тэр даруй, бүрэн хэрэгжих нөхцөлийг нэмж тусгах;
- Гишүүний үйл ажиллагаа, зөвлөмж шаардлагад хөндлөнгөөс нөлөөлөх боломжгүй байх хамгаалалтаар хангаж өгөх.

ТАВ. БУСАД АСУУДАЛ

ННФ -ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер Б.Хишигсайхан, МХХ-ны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Ц.Жаргалан

Эрүүдэн шүүхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд хамаарал бүхий, мөн Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргийг орхигдуулахгүйн үүднээс энэ хүрээнд хамаарах олон чимхлүүр асуудлаар НҮБ-ын хүний эрхийн механизмаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийг нэгтгэж, товч тайлбар, санал, зөвлөмж бүхий байдлаар энэ хэсэгт тусгалаа.

5.1. Эрүүдэн шүүж олсон нотлох баримт нотлох чанараа алдах тухай

Монгол Улс ЭШЭК-ийг соёрхон баталсан улсын хувьд 15 дугаар зүйлийн дагуу “эрүүдэн шүүж олж авсан мэдүүлгийг нотлох баримтаар тооцохгүй байх, харин эрүүдэн шүүлт тулгасан хэргийн нотлох баримт болгох” заалтыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсний зэрэгцээ эрүүдэн шүүх замаар олж авсан нотлох баримт нотлох чанараа алдах тухай НҮБ-ын ХЭЗ-ийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит тогтмол хэлэлцүүлгээс өгсөн зөвлөмжүүдийг⁵⁰ хэрэгжүүлэхээр амлалт авсан. Энэ үүргийг онц болон дайн бүхий нөхцөлд ч мөрдөх ёстой.⁵¹ Хэдийгээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлэг дангаараа гэм буруутайг тогтоох шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй байх зарчмыг⁵² тусгасан нь тун чухал алхам болсон хэдий ч эрүүдэн шүүж олж авсан нотлох баримтыг нотлох баримтаар тооцохгүй байхыг хатуу зохицуулаагүй юм.

Зөвлөмж: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.12.1 дэх заалтыг өөрчлөн найруулж, ЭШЭК-д бүрэн нийцүүлэх.

⁵⁰ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I цикл, 2010 он, Гана Улс 84.21, Нидерланд Улс 84.22

⁵¹ Association for the Prevention of Torture and Convention against Torture Initiative, Guide on anti-torture legislation, 2016, p.27

⁵² УИХ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он, 16.3 дугаар зүйлийн 8.3 дах заалт

5.2. Ял шийтгэлээс мултрахтай тэмцэх

Хуучин Эрүүгийн хуулийн 44.1 дүгээр зүйлийг цуцлах эсхүл өөрчлөн найруулах замаар хүний эрхийн зөрчил үйлдсэн этгээдийг ял шийтгэлээс мултрахаас сэргийлэх тухай Англи Улсын зөвлөмжийг⁵³ хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан хэдий ч шинэ Эрүүгийн хуулийн 4.6 дугаар зүйл буюу “Тушаал, даалгавар биелүүлэх” заалтад “... хууль бус тушаал, даалгаврыг мэдэх боломжгүй, мэдэлгүйгээр биелүүлж энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд хохирол учруулсныг гэмт хэрэгт тооцохгүй” гэж тусгасан нь дээрх үүрэг амлалттай зөрчилдөж байна. Үүний зэрэгцээ ЭШЭК-ийн оролцогч улсын хувьд ял шийтгэлээс мултрахаас сэргийлэх чиглэлээр тодорхой үүрэг хүлээсэн байдаг. Энэ хүрээнд “эрүүдэн шүүх” гэмт хэрэгт өршөөл үзүүлэхийг хориглодог.⁵⁴ Манай хууль тогтоомжид өршөөл үзүүлэхгүй байх тухай хязгаарлалт байхгүй. Үүний зэрэгцээ Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан “эрүүдэн шүүх” гэмт хэрэг үйлдсэн этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хорих ялыг тэнсэхээр байна.⁵⁵

Зөвлөмж: Эрүүгийн хуулийн 4.6 дугаар зүйлийг “...хууль бус тушаал, даалгавар биелүүлсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөхгүй...” хэмээх байдлаар өөрчлөн найруулах, мөн ял завшихаас сэргийлэх зохицуулалтыг боловсронгуй болгох.

5.3. Хуульч, хууль сахиулагчдыг чадавхжуулах

НҮБ-ын ХЭЗ-өөс өгсөн олон улсын хэм хэмжээг үр дүнтэй хэрэглэх чиглэлээр шүүгч, хууль сахиулагчдыг сургах, эрүүдэн шүүх, хүнлэг бус, хэрцгий харьцаанаас урьдчилан сэргийлэх

⁵³ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I цикл, Англи Улс, Зөвлөмж 84.19

⁵⁴ Association for the Prevention of Torture and Convention against Torture Initiative, Guide on anti-torture legislation, 2016, p.43

⁵⁵ УИХ, Эрүүгийн хууль, 2015 он, 6.7 дугаар зүйл 1.2 дах заалт

зорилгоор цагдаагийн алба хаагчийн сургалтын хөтөлбөрийг сайжруулах, хууль сахиулагчдыг сургах тухай зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан.⁵⁶ Мөн Хүний эрхийн хороо Истанбулын протоколд нийцсэн сургалтад хууль сахиулагчдыг хамруулахыг⁵⁷, ЭШЭХ “шүүгч, прокурор, хуульч, хуульч сахиулагчдад ЭШЭК болон эрүү шүүлтийг бүрэн хориглосон талаарх сургалтыг явуулах, Истанбулын протоколын дагуу эрүүл мэндийн мэргэжилтэн болон эрх чөлөөг нь хязгаарласан хүмүүстэй ажилладаг бусад төрийн албан хаагчийн сургалтад заавал оруулах, сургалтын үр дүн, үр нөлөөг хэмждэг арга зүй нэвтрүүлэхийг тус тус зөвлөжээ.⁵⁸ Манай улсын тухайд эрүүдэн шүүх асуудлаар хуульч, хууль сахиулагчдыг сургах чиглэлээр тодорхой алхмууд авч хэрэгжүүлдэг ч бусад мэргэжилтэн, тухайлбал, эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, асрамж, халамжийн газрын ажилтнууд, цэргийн анги нэгтгэлийн алба хаагчдад энэ чиглэлийн сургалт зохион байгуулах талаар сул байна.

Зөвлөмж: Сургалтын хөтөлбөрийг Истанбулын протоколд нийцүүлэн боловсруулах, хуульч, хууль сахиулагчдаас гадна эмнэлгийн мэргэжилтэн, бусад холбогдох ажилтнуудыг сургахад анхаарах.

5.4. Цагдан хорих, хорих байрны нөхцөлийг дээрдүүлэх

Цагдан хорих, хорих байрны нөхцөлийг дээрдүүлэх, цагдан хоригдогсодтой харьцах нөхцөлийг сайжруулах зохистой алхмуудыг авч хэрэгжүүлэх, шоронгийн нөхцөлийг НҮБ-ын Хоригдож буй болон цагдан хоригдож буй бүх хүнийг хамгаалах наад захын жишиг дүрэм, Хоригдогсодтой харьцах наад захын жишиг дүрмүүдэд нийцүүлэх⁵⁹ тухай зөвлөмжийг НҮБ-

ын хүний эрхийн механизмаас удаа дараа авч ирсэн.

Зөвлөмж: Цагдан хорих, хорих байрны нөхцөлийг сайжруулах алхмыг шат дараатай авч хэрэгжүүлэх.

5.5. Мөрдөн шалгах нууц ажиллагаа

Мөрдөн шалгах нууц ажиллагааны хүрээнд олж авсан нотлох баримттай яллагдагч, түүний өмгөөлөгч танилцах боломжтой болсон нь ахиц дэвшил хэдий ч зөвшөөрлийг өгөх систем нь прокурор биш шүүхэд байх нь хүний эрхийг бүрэн хангахад чухал зохицуулалт юм. Мөн цагдан хорих байранд “мөрдөн шалгах нууц ажиллагаа” явуулахыг бүрмөсөн хориглохгүй бол эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд тодорхой ахиц гарахгүй. Энэ асуудлаар ННФ-аас 2015 онд нийтлүүлсэн “Хуулийн шүүмж” цувралын 14 дүгээрт тодорхой дүн шинжилгээ, санал тусгасан болно.⁶⁰

Зөвлөмж: Цагдан хорих байранд “гүйцэтгэх ажил” явуулахыг хориглох, мөрдөн шалгах нууц ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг “шүүх” олгодог байх, зөвшөөрлийн хүрээ, хязгаарыг журмаар биш, хуулиар нарийвчлан зохицуулах.

5.6. Цагдан хорих нийтлэг журмаас татгалзах

Цагдан хорих нийтлэг журам үйлчилж байгаа болон хуулиар хязгаарласнаас урт хугацаагаар цагдан хорьдог, цагдан хорихоос өөр таслан сэргийлэх арга хэмжээний хувилбар байхгүй гэсэн шүүмжийг ЭШЭХ өгсөн.⁶¹

Зөвлөмж: “Зорчих эрхийг хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээ”-г хэрэгжүүлэх эрх зүйн, захиргааны орчныг даруй бүрдүүлэх.

⁵⁶ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I, II цикл, 2010 он, 2015 он, Малайз Улс 84.14, Франц Улс, 108.73, Коста Рика, 108.81

⁵⁷ UN Human Rights Committee, Concluding Observations on the sixth periodic report of Mongolia, 2017, CCPR/C/MNG/CO/6, para. 22

⁵⁸ UN CAT, Concluding Observations on the second periodic report of Mongolia, 2016, CAT/C/MNG/CO/2, para. 37, 38

⁵⁹ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I, II цикл, 2010, 2015 он, Шинэ Зеланд, 84.79, Чех Улс, 108.72, Япон, 108.82, ЭШЭХ-ны Дүгнэлт зөвлөмж,

2016.09.05, CAT/C/MNG/CO/2, параграф 19, 20

⁶⁰ Нээлттэй Нийгэм Форум, Хуулийн шүүмж №, 2015 он, www.forum.mn

⁶¹ UN CAT, Concluding Observations on the second periodic report of Mongolia, 2016, CAT/C/MNG/CO/2, para. 13

5.7. Хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулах тухай

Хууль сануулахгүй баривчилсан тоо, хууль зүйн туслалцаа авалгүйгээр эрхээ хязгаарлуулсан хүний тоо, мэдүүлэг авах үед хуульчдыг байлцуулахгүй тохиолдол их байгаа, тэрчлэн өмгөөлөгч авах, шүүхэд гомдол гаргах, эргэлт уулзалт авах эрхийг сануулдаггүй, төлбөрийн чадваргүй яллагдагч хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй авахын тулд Хууль зүйн туслалцааны төв, Монголын хуульчдын холбоонд заавал албан бичгээр хүсэлт гаргах шаардлагатай байдаг, Хороонд ирсэн тодорхой тооны хэргээс прокурор, мөрдөгч нь гэмт хэрэгт яллагдаж буй этгээдийг хэргээ хүлээсэн нөхцөлд л гэр бүлтэйгээ уулзах эрхийг өгдөг, зарим тохиолдолд гэр бүлээсээ алс газарт хоригдсоны улмаас уулзахад хүндрэлтэй болж байгаад ЭШЭХ шүүмжлэлтэй хандсан.⁶²

Зөвлөмж: Хууль зүйн туслалцаа авах эрхийг аль болох эрт шатнаас хангах шаардлагыг хуульд тусгах, “томилогдсон өмгөөлөгч” хэмээх тодорхой бус зохицуулалтыг тодорхой болгох.

5.8. Шилжүүлэн өгөхгүй байх тухай

Эрүүдэн шүүх хангалттай үндэслэл байгаа бол уг этгээдийг өөр улсад албадан гаргах, буцаах буюу шилжүүлэн өгөхгүй байх үр дүнтэй эрх зүйн, шүүхийн, захиргааны тогтолцоог ЭШЭХ-ийн 3-р зүйлд нийцүүлэн бүрдүүлэх, шилжүүлэх шийдвэр гарсан тохиолдолд уг этгээдийн шүүхэд давах эрхийг хангах, хэрэв эрүүдэн шүүгдэх хангалттай үндэслэл байгаа тохиолдолд албадан гаргахгүй байх баталгаагаар хангагдах, хоёр талын болон олон талт гэрээ байгуулахдаа тус зарчмыг хүндэтгэх, дүрвэгсдийн конвенц, протоколд нэгдэх асуудлыг судлахыг ЭШЭХ зөвлөсөн.⁶³

Зөвлөмж: Олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх.

⁶² UN CAT, Concluding Observations on the second periodic report of Mongolia, 2016, CAT/C/MNG/CO/2, para. 11, 13

⁶³ UN CAT, Concluding Observations on the second periodic report of Mongolia, 2016, CAT/C/MNG/CO/2, para. 35, 36

5.9. ЭШЭХ-ны хувь хүний, улс хоорондын гомдол мэдээллийн журмыг хүлээн зөвшөөрөх тухай мэдэгдэл

ЭШЭХ-ийн 21⁶⁴, 22⁶⁵-р зүйлийг хүлээн зөвшөөрч байгаа тухай мэдэгдлийг Эрүүдэн шүүхийн эсрэг хороонд хүргүүлэхээр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг I, II циклийн үеэр Бразил, Испани, Алжир, Дани, Польш улсуудын өгсөн зөвлөмжийг⁶⁶ хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан болно.

Зөвлөмж: Мэдэгдлийг ЭШЭХ-нд хүргүүлэх.

5.10. Бие махбодын шийтгэлийг хориглох

Бие махбодын шийтгэлийг хориглохдоо ЭШЭХ-д нийцүүлэн хуульчлах⁶⁷, Эрүүдэн шүүхийн эсрэг тусгай илтгэгчийн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарахыг⁶⁸ улс орнууд зөвлөсөн байна.

Зөвлөмж: Хүүхдийн эсрэг бие махбодын шийтгэл хэрэглэхийг хориглосон хууль тогтоомжийг сурталчлан таниулах.

⁶⁴ НҮБ-ын НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 39/46, Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх тухай конвенц, 1984 он, Монгол Улс 2002 онд соёрхон баталсан. Хорооны улс хоорондын гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх эрх хэмжээ, Зүйл 21

⁶⁵ НҮБ-ын НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 39/46, Эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх тухай конвенц, 1984 он, Монгол Улс 2002 онд соёрхон баталсан. Хороо оролцогч улсын талаар гаргасан хувь хүний гомдлыг хянан шийдвэрлэх эрх хэмжээ, Зүйл 22

⁶⁶ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I, II цикл, 2010, 2015 он, Бразил 84.18, Итали 84.15, Чили 108.6, Швед 108.107, ЭШЭХ-ны Дүгнэлт зөвлөмж, 2016.09.05, CAT/C/MNG/CO/2, параграф 25, 26

⁶⁷ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I, II цикл, 2010, 2015 он, Бразил 84.18, Итали 84.15, Чили 108.6, Швед 108.107, ЭШЭХ-ны Дүгнэлт зөвлөмж, 2016.09.05, CAT/C/MNG/CO/2, параграф 25, 26

⁶⁸ НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ажлын хэсгийн хуралдааны тайлан, Хүний эрхийн төлөв байдлын ээлжит түгээмэл хэлэлцүүлэг I цикл, 2010 он, Казахстан, 84.72